



**МОНГОЛЫН САГСАН  
БӨМБӨГИЙН ХОЛБОО ТББ**

1016245, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
8-р хороо, Сүхбаатар талбай,  
Сэнтрал Тауэр 4 давхар, 407а  
Tel.(976)-88886579.(976)-77114144

АНАБ. 01.17 № 11  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

“ЭРДЭНЭТИЙН УУРХАЙЧИН” БАГТ

**Мэдэгдэл хүргүүлэх тухай**

Монголын Сагсан бөмбөгийн Холбоо НҮТББ /цаашид “Холбоо” гэх/-аас зохион байгуулж байгаа Үндэсний дээд лигийн 2022-2023 оны улирлын тэмцээний 2023 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн “Эрдэнэтийн уурхайчин”, “М-Гарьд” багуудын тоглолтын үеэр танай багийн тоглогчид Үндэсний дээд лигийн тэмцээнийг зохион байгуулах журам /цаашид “Лигийн тэмцээний журам” гэх/ болон Багуудтай байгуулсан хариуцлагыг гэрээг зөрчсөн үйлдэл гаргасан байна.

Багуудын тоглолтын 4-р үеийн 06'28 минутын үед “М-Гарьд” багийн тоглогч Б.Мөнхболдын “Эрдэнэтийн Уурхайчид” багийн тоглогч Г.Ган-Эрдэнэтэй бөмбөг булаалдах үед гаргасан алдааны улмаас 2 багийн тоглогчид маргаан гаргаж, энэ үйлдэлд бухимдсан зарим үзэгчидээс тоглолтын талбайд усны сав шидэж, үзэгчидтэй тоглогчид маргалдан, эмх замбараагүй байдал үүсэж болзошгүй зохисгүй явдал гарсан. Тоглолтын үед гаргасан тоглогчдын алдаанд талбайн шүүгчид дүрмийн дагуу шийдвэрийг гаргаж хариуцлага хүлээлгэсэн.

Гэхдээ эдгээр үйлдэл нь тоглогчдийн өөрсдийн хувийн ёс зүй, сахилга хариуцлагын зөрчил байсан бөгөөд Лигийн Мэргэжлийн зөвлөл болон Ажлын хэсгийг нэгтгэсэн хуралдаанаар Лигийн тэмцээний журам болон Багуудтай байгуулсан хариуцлагыг гэрээг үндэслэн доорхи зөрчлийг ногдуулан шийдвэрлэснийг үүгээр мэдэгдэж байна. Үүнд:

1. “Эрдэнэтийн Уурхайчид” багийн тоглогч Т.Санчир үзэгчидээс шидсэн усны савыг шидсэн хүн рүү хариу шидэхээр үйлдэл гарган маргаж, тэмцээн зохион байгуулагчдын зүгээс үйлдлийг зогсоож хориглосоор байхад үзэгчидрүү дахин дахин дайрсан нь өөрийгөө болон бусад тоглогчдын аюулгүй байдлыг эрсдэлд оруулах байдлыг бий болгосон төдийгүй тэмцээний Журмын 5.1-т “Лигийн тэмцээнд оролцож байгаа багийн эзэд, менежер, дасгалжуулагч, тоглогч, шүүгч, багийн албаны хүмүүс, Ажлын хэсэг нь сагсан бөмбөгийн спортыг хүндэтгэн, олон нийтийн дунд лигийн тэмцээн, баг, тамирчдын нэр хүнд, ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэн холбооны дүрэм, энэхүү журмыг баримтлах үүрэг хүлээнэ” гэсэн заалтыг зөрчиж, лигийн тамирчны үүргийг биелүүлээгүй байна. Энэ нь Лигийн тэмцээний журмын Хавсралтад заасан Зөрчлийн хэлбэрийн 1.1 болон 1.5-д заасан зөрчлийг гаргасан бөгөөд хариуцлага хэсгийн 2-ийн хоёрт зааснаар 1 /нэг/ тоглолт өнжүүлэх шийтгэл оногдуулсан;
2. Тоглогч Г.Ган-Эрдэнэ, Г.Болор-Эрдэнэ нар нь эсрэг багийн тоглогчтой маргах, маргаанд өдөөн турхирч мандаттай оролцогчтой хүндэтгэлгүй хандсан нь Журмын Хавсралтад заасан Зөрчлийн хэлбэрийн 1.1-д заасан зөрчлийг гаргасан байх тул тус бүрийг албан ёсоор сануулах шийтгэлийг тус тус оногдуулсан болно. Багийн тоглогчид дахин ийм үйлдэл гаргасан тохиолдолд торгох, тоглолт өнжүүлэх, тоглолтоос хөөх, заалнаас чөлөөлөх, мандат хураах зэрэг шийтгэл оногдуулах болохыг анхааруулж байна.

Цаашид та бүхэн багийн бүрэлдэхүүнд багтаж буй дасгалжуулагч, тоглогчид, багийн албаны хүмүүст Лигийн тэмцээн зохион байгуулах журам болон багуудын хариуцлагын гэрээг сайтар танилцуулж, Олон улсын сагсан бөмбөгийн холбооны дүрэм болон Холбооны дүрэм, Лигийн тэмцээнийг зохион байгуулах журмыг баримтлан, тэмцээндээ хүндэтгэлтэй хандаж, ёс зүйтэй байж тэмцээнийг амжилттай зохион байгуулах тал дээр хамтран ажиллана уу.

/Албан бичгийг нийтийн мэдээллийн сайтад байршуулна./

ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



С.ТӨГСЖАРГАЛ